

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ИНДРА

1118265139 1115064

**/УБ ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 10 ДУГААР ХОРОО/ ЦАГДААГИЙН ХАНГАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗҮҮН ТАЛЫН АВТО ЗАМ/-ЫН ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТ**

1. Ерөнхий зүйл	<p>Объектын нэр: Цагдаагийн хангамж үйлчилгээний төвийн зүүн талын авто зам. /БЗД-ийн 10-р хороо/</p> <p>Зураг төслийн иж бүрдэл:</p> <ul style="list-style-type: none">• Ажлын зураг• Тайлбар бичиг• Техникийн шаардлага• Байр зүйн зураглалын ажлын тайлан• Инженер геологийн судалгааны ажлын тайлан• Магадлалын дүгнэлт• Хяналтын төсөв. <p>Гудамж замын ангилал: Нутаг дэвсгэрийн гол гудамж зам.</p>
2. Барилгын талбайн үзүүлэлт	Одоо байгаа шороон замыг сайжруулан хатуу хучилттай авто зам барих.
3. Ажлын цар хүрээ	<ol style="list-style-type: none">1) Зураг төсөл боловсруулалт нь зургийн даалгаврыг үндэслэнэ.2) Төслийн авто замын ажлын нийт уртыг зураг төслийн шатанд нарийвчлан гаргах,3) Авто замын хучилтын хийцийг тооцоогоор үндэслэх.4) Зураг төсөл боловсруулах явцад холбогдох шугам сүлжээний байгууллагуудаас тодруулга авах.5) Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц гарцыг төлөвлөх,6) гадаргуугийн усыг зайлуулалтыг төсөллөх.
4. Ажлын хил хязгаар	БЗД-ийн 10-р хороо, Цагдаагийн ерөнхий газрын хангамжийн төвийн зүүн урд талаас Улаанхуаран гудамжны 1166 тоот хашаа хүртэлх авто зам.
5. Барилгын ажлын зохион байгуулалт	<ol style="list-style-type: none">1) Ажлын зураг төсөл боловсруулах ажил, барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагаас ажил эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгж гүйцэтгэнэ.2) Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг тэмдэглэгээ г.м/ -ыг бүрэн хангаж ажиллана.

	<p>3) Гүйцэтгэгч байгууллага Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын даргын 2016 оны А/42 тоот тушаалаар батлагдсан <u>“Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага” ыг засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх хугацаанд чанд мөрдөн ажиллана.</u> Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан, холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайланд тусгагдаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар зэргийг ашиглана. Нөгөө талаас холбогдох БНБД-үүд, техник технологийн стандартуудад заасан шаардлагуудыг хангаж ажиллахыг анхаарна уу.</p> <p>4) Тухайн засвар шинэчлэлтийн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч, хүн хүч, машин, механизмийн хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>5) Гүйцэтгэгч нь төслийн нүүлгэн шилжүүлэлтийн ажил /байнгын болон түр ашиглах талбайг оролцуулан/-тай холбоотой дэвсгэр зургийг эрх бүхий байгууллагатай зөвшилцөж эцсийн байдлаар батлуулан захиалагчид хүлээлгэн өгнө.</p> <p>6) Захиалагч барилгын ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба өгснөөс хойш ашиглалтад оруулах хүртэл хугацаанд ажлын талбайг эзэмших эрхийг захиалагч бичгээр баталгаажуулна. Энэ хугацаанд гүйцэтгэгч нь аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p> <p>7) Гүйцэтгэгч нь газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээг чөлөөлөх, шилжүүлэх, хамгаалах ажлыг хариуцна. Үүнд: цахилгаан, холбоо, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, борооны ус зайлуулах байгууламж, троллейбус болон гэрэлтүүлгийн шугам гэх мэт. Энэ ажилтай холбоотой гарах бүх зардлыг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>8) Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулна. Авто замын ажлыг батлагдсан төлөвлөгөө, аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна.</p> <p>9) Ажил гүйцэтгэх үедээ карьер нээх, хог хаягдал хаях төвлөрсөн цэг нээх зэрэг ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлуудын талаар харьяалах дүүргийн</p>
--	--


	засаг захиргааны удирдах албаны ажилтнууд болон байгаль орчны байцаагчидтай харилцан зөвшилцөж ажиллана.
6. Бусад	Барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

Хянасан:

НАЗХГ-ын Орлогч даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч


 Д.Төрбилэг

Бодлого зохицуулалтын хэлтсийн даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч

 О.Энхбаатар

Боловсруулсан:

Бодлого зохицуулалтын хэлтсийн
Авто замын төлөвлөлтийн мэргэжилтэн

 А.Оюунчимэг

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай
инженер техникийн ажилтан**

№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага /жил/
1	Ерөнхий инженер /Авто замын инженер/	1	5 болон түүнээс дээш
2	Талбайн /Авто замын/ инженер	1	2 болон түүнээс дээш
3	Геодезийн инженер	1	2 болон түүнээс дээш
4	Материалын инженер	1	2 болон түүнээс дээш
5	Хөдөлмөрхамгааллын инженер	1	2 болон түүнээс дээш
6	Шугамсүлжээний инженер	1	2 болон түүнээс дээш

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай
машин механизмууд**

No	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Автогрейдер	шр	1	140 м.х-с дээш	Өөрийн
2	Авто кран	шр	1	8 тн, 15 тн	Өөрийн
3	Усны машин	шр	1	5 тн-с дээш	Өөрийн
4	Экскаватор	шр	2	0.5 м3 - 2 м3	Өөрийн болон түрээсийн
5	Ачааны автомашин	шр	8	15 тн	Өөрийн болон түрээсийн
6	Авто ачигч	шр	2	1.5– 5 м3	Өөрийн болон түрээс
7	Индүү /доргиурт/	шр	2	10 – 18 тн	Өөрийн болон түрээс
8	Хийн дугуйт индүү	шр	2	5-8 тн, 14 – 16 тн,	Өөрийн
9	Индүү /гөлгөр булт/	шр	3	10-12тн, 18-20тн	Өөрийн
10	Ачааны автомашин	шр	1	5 тн	Өөрийн болон түрээс
11	Асфальтбетон дэвсэгч	шр	1	/өргөний хэмжээ 7-12м/	Өөрийн болон түрээс
12	Авто гидронатор /цацагчаар тоноглогдсон байна/	шр	1	6000 л	Өөрийн болон түрээс

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай
тоног төхөөрөмжүүд:**

No	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Компрессор	шр	1	110 м.х	Өөрийн
2	Нүүдлийн цахилгаан үүсгүүр	шр	1	30 квт-аас багагүй	Өөрийн болон түрээс

3	Зөөврийн гагнуурын аппарат	шр	1	500 а	Өөрийн
6	Гар нягтруулагч	шр	2		Өөрийн
7	Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлэг	шр	2		Өөрийн болон түрээс
8	Замын хашлага тавих хайч /босоо, хэвтээ/	шр	6		Өөрийн
9	Гэрэл ойлгогчтой зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз, угсардаг хашаа	Хангалттай хэмжээгээр			
10	Бага оврын гар хөрс нягтруулагч төхөөрөмж	шр	2	90 кг, 120 кг	Өөрийн
11	Автомат нивелир, теодолит /сүүлийн үеийн/	шр	1	Баталгаажсан	Өөрийн
12	Асфальтбетон зүсэгч болон чулуу зүсэгч хөрөө	шр	1		Өөрийн
13	Иж бүрэн талбайн лаборатори	шр	1		Өөрийн болон түрээс
13	Талбайн дээрх ажлыг фото зургаар баталгаажуулахад шаардагдах багаж хэрэгсэл /Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага 2017-д тусгагдсан/	ком	1		Өөрийн
14	Нийтэд мэдээлэх самбар /2*3 /	шр	2		Өөрийн

Хянасан:


НАЗХГ-ын орлогч даргын

үүргийг түр орлон гүйцэтгэгч

 Д.Төрбилэг

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын


ЗАХХ-ийн Ахлах мэргэжилтэн

 Д.Заансүх

Боловсруулсан:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын

ЗАХХ-ийн Авто замын хяналтын мэргэжилтэн:

 Б.Жаргалсайхан